

БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2021 оны III улирлын санхүүгийн тайлан

Банк бус санхүүгийн байгууллагын газар

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668

Агуулга

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	7
“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт.....	7
“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт .7	
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид	9
Хувьцаа эзэмшигчид, ажилчид	9
Тархалт	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгөн хөрөнгө.....	12
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	12
Факторингийн тооцооны авлага.....	13
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө	13
Зээл.....	13
Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд.....	15
Бусад хөрөнгө	17
Эргэлтийн бус хөрөнгө	17
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	18
Санхүүгийн эх үүсвэр	18
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	19
Бусад эх үүсвэр	20
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	20
Төслийн зээлийн санхүүжилт.....	21
Бусад өр төлбөр	21
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	21
Бусад өмч, сангууд	22
Хуримтлагдсан ашиг	23
Хоёрдогч өглөг.....	23
Ашигт ажиллагаа	24
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	26
Дүгнэлт	27

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоон мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл.....	9
Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	9
Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл	9
Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/	11
Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	12
Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	12
Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	13
Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	13
Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/.....	15
Хүснэгт 18 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/.....	15
Хүснэгт 19 Уламжлалт болон финтек зээлийн тоо мэдээ	16
Хүснэгт 20 Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд.....	16
Хүснэгт 21 Зээл олгож буй аппликэйшнүүд.....	16
Хүснэгт 22 Мост мони-д холбогдсон ББСБ-ууд	16
Хүснэгт 23 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/.....	17
Хүснэгт 24 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	17
Хүснэгт 25 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	18
Хүснэгт 26 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/	19
Хүснэгт 27 Итгэлцлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ууд /сая төгрөгөөр/	19
Хүснэгт 28 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/.....	19
Хүснэгт 29 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	20
Хүснэгт 30 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/.....	20
Хүснэгт 31 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	21
Хүснэгт 32 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/	21
Хүснэгт 33 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 34 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	22
Хүснэгт 35 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	23
Хүснэгт 36 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/.....	23
Хүснэгт 37 Хоёрдогч өглөгийн дүн сүүлийн 5 жилийн байдлаар /сая төгрөгөөр/	23
Хүснэгт 38 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/.....	24
Хүснэгт 39 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	25
Хүснэгт 40 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	26

Зургийн жагсаалт

Зураг 1 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	11
Зураг 2 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	12
Зураг 3 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/	14
Зураг 4 Зээлийн багцын чанар /хувиар/.....	14
Зураг 5 Олгосон зээл /хугацааны ангиллаар/	15
Зураг 6 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	18
Зураг 7 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	18

Зураг 8 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /тэрбум төгрөгөөр/	20
Зураг 9 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	20
Зураг 10 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	22
Зураг 11 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	24
Зураг 12 Хүүгийн бус зардлын өсөлтийн бүтэц	25

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2021 оны III улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 531 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 ББСБ буюу 0.4 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 80 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 29 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоон мэдээлэл

	III улирал				
	2017	2018	2019	2020	2021
Шинээр олгосон	9	13	9	12	9
Хүчингүй	7	7	9	8	10
Түдгэлзүүлсэн	1	17	10	25	20
Сэргээсэн	8	7	8	4	6
Нийт ББСБ	535	540	539	533	531
Үүнээс: ХОН	70	76	74	77	80
Үүнээс: ГХО	29	28	28	29	29
Салбар	139	206	240	285	313
Төлөөлөгч	4	5	7	9	8

Тайлант хугацаанд нийт 9 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 10 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 20 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 6 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2021 оны III улирлын байдлаар 24 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2020-III	2021-III	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	1,942.1	2,460.1	26.7%
Банкны салбартай харьцуулахад хувиар	5.6%	6.2%	0.6%
Нийт өөрийн хөрөнгө	1,376.6	1,682.1	22.2%
Банкны салбартай харьцуулахад хувиар	46.1%	52.1%	6.0%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	979.5	1,078.4	10.1%
Банкны салбартай харьцуулахад хувиар	130.5%	100.5%	-30.0%
Нийт зээл	1,357.8	1,765.9	30.1%
Банкны салбартай харьцуулахад хувиар	7.6%	8.6%	1.0%
Нийт орлого	303.9	354.2	16.5%
Нийт зарлага	189.3	206.4	9.0%
Цэвэр ашиг	114.6	147.8	29.0%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 518.0 тэрбум төгрөгөөр буюу 26.7 хувиар өсөж 2.5 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын 6.2%-тай тэнцэж байна. Активын өсөлтийн 78.8 хувийг нийт зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 59.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 16.5 хувиар буюу 50.3 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 9.0 хувиар буюу 17.1 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 28.9 хувиар буюу 33.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2020-III	2021-III	тоо	хувь
Нийт ББСБ-ын тоо		533	531	(2)	-0.4%
1	Зээл	495	493	(2)	-0.4%
Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг		333	324	(9)	-2.7%
2	Факторинг	34	38	4	11.8%
3	Төлбөрийн баталгаа гаргах	20	22	2	10.0%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	5	-	-
5	Пахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	33	35	2	6.1%
6	Гадаад валютын арилжаа	153	147	(6)	-3.9%
Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг		38	38	-	-
7	Итгэлцэл	42	46	4	9.5%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	10	18	8	80.0%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	37	39	2	5.4%

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 531 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 92.8% нь буюу 493 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 61.0% нь буюу 324 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 147 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 27.7 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 38 ББСБ нийт ББСБ-уудын 7.2 хувийг бүрдүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь

ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 80.0 хувиар, факторингийн үйлчилгээ 11.8 хувиар, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ 10.0 хувиар тус тус өссөн байна.

2021 оны III улирлын тайлан мэдээний ирц 93.0% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 531 ББСБ-аас 494 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 37 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Тайлант хугацаанд 3 улирал дараалан тайлангаа ирүүлээгүй 1 ББСБ, 2 улирал дараалан тайлангаа ирүүлээгүй 3 ББСБ байна.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах дүрэм журмуудыг шинэчлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

- “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [65 дугаар тогтоолоор](#) батлуулсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авсан. Үүний дараагаар дээрх тогтоолыг сунгаж, 2021 оны 9 дүгээр сарын 22-ний өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [385 дугаар тогтоолоор](#) баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авсан.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 441 дүгээр тогтоол /Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай/-ын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолыг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [66 дугаар тогтоолоор](#) батлуулсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авсан.

- “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулж, 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [165 дугаар тогтоолоор](#) баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 5237 дугаарт бүртгэсэн.

- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед банк бус санхүүгийн байгууллагуудад хэрэгжүүлэх арга хэмжээний тухай (2021 оныг дуустал зээлийн гэрээнд 2 ба түүнээс дээш удаа өөрчлөлт оруулсан тохиолдолд ангилал бууруулан бүртгэх журмын үйлчлэлийг түр зогсоох мөн 60 хоног хүртэлх хугацаанд хэвийн ангилалд ангилан бүртгэнэ.) тогтоолыг боловсруулж, 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [262 дугаар тогтоолоор](#) батлуулсан.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2021 оны III улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 85.9% буюу 458 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 432 ББСБ хэрэгжүүлсэн байна.

“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 493 ББСБ-ын 84.4% буюу 416 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7

дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 158 ББСБ, 12,414 удаагийн тохиолдлоор, 1.0 их наяд төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт,

журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 6 ББСБ, 19 удаагийн тохиолдлоор, 820.1 сая төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2021 оны III улирлын байдлаар нийт 525 ББСБ-аас 1.3 тэрбум төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 87.0% буюу 474 ББСБ 1.1 тэрбум төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2021 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 21,666 хувьцаа эзэмшигчдийн 531 ББСБ, 313 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 3,820 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.5 сая харилцагч, 1.6 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,530,126	1,505,601	308,440	4,221,686	27,181	4,513,897	16,229	1,244,954	76,982
Үүнээс: Эмэгтэй	2,714,812	816,544	158,328	2,556,484	13,549	2,705,560	9,252	681,743	40,104
Эрэгтэй	1,809,718	688,424	144,917	1,664,801	11,906	1,802,802	6,916	562,870	36,674
Хуулийн этгээд	5,596	633	5,195	401	1,726	5,535	61	341	204
Итгэмжлэгчдийн тоо	3,930	3,930	2,275	1,655	-	3,926	4	259	233
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,111	983	298	813	-	1,109	2	756	175
Зээлдэгчдийн тоо	1,562,757	505,018	244,249	1,318,508	-	1,546,804	15,953	260,159	76,982
Үүнээс: Иргэн	1,561,098	504,488	242,728	1,318,370	-	1,545,199	15,899	260,079	76,598
Хуулийн этгээд	1,659	530	1,521	138	-	1,605	54	80	384
Хэвийн	1,468,204	431,402	217,178	1,251,026	-	1,453,975	14,229	204,926	65,047
Анхаарал хандуулах	32,809	25,909	10,021	22,788	-	32,293	516	18,678	4,694
Чанаргүй:	61,744	47,707	17,050	44,694	-	60,536	1,208	36,555	7,241
-Хэвийн бус	17,824	14,659	5,387	12,437	-	17,523	301	10,790	2,170
-Эргэлзээтэй	12,998	10,746	3,817	9,181	-	12,790	208	8,175	1,481
-Муу	30,922	22,302	7,846	23,076	-	30,223	699	17,590	3,590
Зээлдэгчдийн насжилт	1,561,098	504,488	242,728	1,318,370	-	1,545,199	15,899	260,079	76,598
18-35 насны	459,650	292,347	123,431	336,219	-	453,780	5,870	165,032	47,106
36-45 насны	980,169	126,854	71,878	908,291	-	974,911	5,258	60,077	18,223
46-55 насны	91,241	63,057	36,059	55,182	-	87,831	3,410	27,621	9,017
55-аас дээш	30,038	22,230	11,360	18,678	-	28,677	1,361	7,349	2,252
Зээлдэгчдийн боловсрол	1,561,098	504,488	242,728	1,318,370	-	1,545,199	15,899	260,079	76,598
-Дээд	1,226,094	267,030	140,866	1,085,228	-	1,218,108	7,986	153,051	47,438
-Тусгай дунд	80,508	43,796	29,558	50,950	-	77,202	3,306	14,445	11,571
-Бүрэн дунд	197,578	154,732	54,252	143,326	-	194,853	2,725	79,580	14,622
-Дунд	44,504	27,910	13,797	30,707	-	43,309	1,195	9,213	2,788
-Бага	12,413	11,019	4,255	8,158	-	11,726	687	3,790	179

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын давхардсан тоогоор өмнөх оны мөн үеэс 71.6 хувиар өсөж 4,530,126-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.8 дахин өсөж 1.6 саяд хүрлээ. Зээлдэгчдийн тоо огцом өссөн нь аппликэйшн ашиглан бага дүнтэй богино хугацаатай хэрэглээний зээл олгодог ББСБ-ууд нэмэгдсэнтэй холбоотой.

Нийт харилцагчдын 2.7 сая буюу 59.7% нь нэр бүхий 2 ББСБ-ын харилцагч, зээлдэгчдийн 799.9 мянга буюу 51.2% нь эдгээр ББСБ-ийн зээлдэгчид байна.

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2017-III	2018-III	2019-III	2020-III	2021-III	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	1,039	4,766	7,672	8,669	21,666	12,997	149.9%
Ажилчдын тоо	2,289	2,652	3,003	3,417	3,820	403	11.8%
Харилцагчдын тоо	1,392,561	1,510,982	1,575,389	2,639,297	4,530,126	1,890,829	71.6%
Зээлдэгчдийн тоо	102,957	217,623	383,670	551,977	1,562,757	1,010,780	183.1%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.5%	3.3%	3.4%	2.9%	2.6%	-0.3 пункт	

Хувьцаа эзэмшигчид, ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өсөж 21,666-д хүрсэн нь мөн нэр бүхий 1 ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 6.7 дахин огцом өссөнтэй холбоотой.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	21,666	20,749	2,630	19,036	62	21,475	191	20,636	1,716
Нийт ажилтнуудын тоо	3,820	1,505	2,696	1,124	96	3,608	212	265	407
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	2,213	814	1,628	585	53	2,066	147	156	229

Нийт хувьцаа эзэмшигчдийн 20,636 буюу 95.2% нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,030 буюу 4.8% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна.

Мөн хувьцаа эзэмшигчдийн 1,716 буюу 7.9% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 191 буюу 0.9% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хөдөө орон нутгийн 80 ББСБ 5 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин тодорхойгүйн улмаас одоогоор тухайн төрлийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ байхгүй байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	531	46	507	24	38	451	80	4	527	29
1 Зээл	493	46	469	24	-	415	78	4	489	29
2 Факторингийн үйлчилгээ	38	15	27	11	-	38	-	2	36	2
3 Төлбөрийн баталгаа гаргах	22	7	19	3	-	22	-	1	21	5
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	1	1	4	-	5	-	1	4	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	35	10	23	12	-	35	-	2	33	1
6 Гадаад валютын арилжаа	147	24	135	12	38	139	8	3	144	9
7 Итгэлцлийн үйлчилгээ	46	46	34	12	-	45	1	4	42	5
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	18	11	14	4	-	17	1	2	16	2
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	39	18	33	6	-	37	2	4	35	5

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 85.3% буюу 457 ББСБ, салбаруудын 68.5% буюу 211 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 14.7% буюу 79 ББСБ, салбаруудын 31.5% буюу 97 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2021 оны III улирлын байдлаар 79 ББСБ-ын 308 салбар бүртгэлтэй байна. Нийт салбарын 65.3 хувийг 14 ББСБ-ын 201 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	451	216	667	100.0%
Сүхбаатар дүүрэг	153	30	183	27.4%
Чингэлтэй дүүрэг	128	32	160	24.0%
Баянгол дүүрэг	75	37	112	16.8%
Баянзүрх дүүрэг	51	53	104	15.6%
Хан-Уул дүүрэг	34	25	59	8.8%
Сонгинохайрхан дүүрэг	9	33	42	6.3%
Багануур дүүрэг	1	4	5	0.7%
Налайх дүүрэг		2	2	0.3%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон аймаг, Улаанбаатар хотоос Сүхбаатар дүүрэгт хамгийн ихээр төвлөрч үйлчилгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	80	97	177	100%
Архангай аймаг	1	2	3	1.7%
Баян-Өлгий аймаг	3	2	5	2.8%
Баянхонгор аймаг	3	5	8	4.5%
Булган аймаг	2	-	2	1.1%
Говь-Алтай аймаг	1	-	1	0.6%
Говьсүмбэр аймаг	2	2	4	2.3%
Дархан-Уул аймаг	7	11	18	10.2%
Дорноговь аймаг	2	6	8	4.5%
Дорнод аймаг	5	8	13	7.3%
Дундговь аймаг	1	3	4	2.3%
Завхан аймаг	2	1	3	1.7%
Орхон аймаг	7	13	20	11.3%
Өвөрхангай аймаг	9	6	15	8.5%
Өмнөговь аймаг	2	10	12	6.8%
Сүхбаатар аймаг	5	3	8	4.5%
Сэлэнгэ аймаг	5	6	11	6.2%
Төв аймаг	14	3	17	9.6%
Увс аймаг	3	4	7	4.0%
Ховд аймаг	1	3	4	2.3%
Хөвсгөл аймаг	3	5	8	4.5%
Хэнтий аймаг	2	4	6	3.4%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2021 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 2.5 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.7 хувиар буюу 518.0 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 78.8 хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхэнтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2020-III дүн	Нийт дүнд эзлэх хувь	2021-III дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	1,868,764.5	96.2%	2,369,244.2	96.3%	500,479.7	26.8%
Мөнгөн хөрөнгө	415,202.6	21.4%	435,923.4	17.7%	20,720.8	5.0%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	9,628.1	0.5%	19,065.9	0.8%	9,437.8	98.0%
Зээл (цэврээр)	1,263,734.5	65.1%	1,648,960.1	67.0%	385,225.6	30.5%
Нийт зээл	1,357,823.9	69.9%	1,765,925.5	71.8%	408,101.6	30.1%
(Зээлийн эрсдэлийн сан)	94,089.4	4.8%	116,965.3	4.8%	22,876.0	24.3%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	4,788.1	0.2%	10,714.3	0.4%	5,926.2	123.8%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	10,854.8	0.6%	12,414.1	0.5%	1,559.2	14.4%
Бусад хөрөнгө	155,994.1	8.0%	242,166.4	9.8%	86,172.3	55.2%
Эргэлтийн бус хөрөнгө	8,562.2	-	0.0	0.0%	-8,562.2	-
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	73,296.8	3.8%	90,866.2	3.7%	17,569.4	24.0%
(Хуримтлагдсан элэгдэл)	91,459.0	4.7%	115,618.7	4.7%	24,159.7	26.4%
Нийт хөрөнгийн дүн	-18,162.2	-0.9%	-24,752.5	-1.0%	-6,590.3	36.3%

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2017 оны мөн үед 906.0 тэрбум төгрөг байсан бол 2021 оны III улирлын байдлаар 2.7 дахин өсөж 2.5 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 2.1 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 1 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 81.5% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 200 ББСБ, 8.5% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 96 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 9.9 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 235 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	1,641.3	90	66.7%	16.9%	6.8	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	364.9	110	14.8%	20.7%	6.3	2	4.5	1	-	-
1.9-2.5 тэрбум	210.0	96	8.5%	18.1%	-	-	2.1	1	-	-
1.4-1.9 тэрбум	176.0	107	7.2%	20.2%	3.1	2	1.7	1	1.8	1
0.6-1.4 тэрбум	45.9	42	1.9%	7.9%	4.4	5	12.0	13	4.0	4
0.6 тэрбум хүртэлх	22.0	86	0.9%	16.2%	1.0	3	11.7	49	8.8	33
НИЙТ	2,460.1	531	100.0%	100.0%	21.5	13	32.0	65	14.6	38

Мөнгөн хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн 31.6% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 39.3% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 29.1% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	435.9	96.6	342.4	93.6	14.1	424.6	11.3	21.7	39.2
Бэлэн мөнгө	137.7	4.3	132.7	5.1	12.0	130.3	7.4	0.0	4.3
Харилцах	171.4	52.7	129.0	42.4	2.2	168.1	3.3	18.2	24.7
Хадгаламж	126.7	39.6	80.6	46.1	0.0	126.2	0.5	3.5	10.1

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 38.8%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 5.4%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 84.7% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Ураг 2 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 98.0% буюу 9.4 тэрбум төгрөгөөр өсөж, 2021 оны III улирлын байдлаар 24 ББСБ 19.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалтын 53.0% буюу 10.1 тэрбум төгрөгийг 14 ББСБ-ын арилжааны үнэт цаас, 47.0% буюу 9.0 тэрбум төгрөгийг 11 ББСБ-ын хөрөнгө оруулалтын үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 70.4% буюу 13.4 тэрбум төгрөг нь хувьцаа, 27.7% буюу 5.3 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 2.0% буюу 381.5 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	19,065.9	17,811.5	8,316.0	10,750.0	1.0	18,385.3	680.6	14,287.6	6,127.5
Хувьцаа	13,419.5	12,276.3	7,889.2	5,530.4	1.0	12,738.9	680.6	11,199.8	6,028.4
Өрийн бичиг	5,288.3	5,179.1	424.8	4,863.5	-	5,288.3	-	2,708.4	99.2
Бусад	381.5	379.5	2.0	379.5	-	381.5	-	379.5	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	8,956.5	8,918.6	6,082.8	2,873.6	-	8,955.5	1.0	6,696.8	6,028.4
Арилжааны үнэт цаас	10,132.9	8,916.3	2,233.1	7,899.7	1.0	9,453.3	679.6	7,590.8	99.2

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 18 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 24 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 10 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй, 14 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байна.

Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 2.2 дахин буюу 6.0 тэрбум төгрөгөөр өсөж 10.8 тэрбум төгрөгт хүрчээ. Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн хэдий ч 2021 оны III улирлын байдлаар 4 ББСБ 639.4 сая төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 115.1 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 10 ББСБ нийт 10.8 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ. Үүний 52.3% буюу 5.6 тэрбум төгрөгийг СЗХ-ны 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 163 дугаар тогтоолоор ББСБ-ын зээл болон факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан нэр бүхий 1 ББСБ-ын факторингийн тооцооны авлагын дүн бүрдүүлж байна.

Факторингийн тусгай зөвшөөрөлтэй 38 ББСБ-уудын 28 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2020-III		2021-III		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
Хэвийн	4,610.5	95.3%	10,190.0	94.1%	5,579.6	121.0%
Анхаарал хандуулах	188.1	3.9%	319.2	2.9%	131.1	69.7%
Чанаргүй	38.2	0.8%	320.2	3.0%	282.0	738.9%
Хэвийн бус	13.3	0.3%	275.7	2.5%	262.4	1966.9%
Эргэлзээтэй	12.6	0.3%	28.5	0.3%	16.0	127.0%
Муу	12.3	0.3%	16.0	0.1%	3.7	30.1%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	48.6	1.0%	115.1	1.1%	66.5	136.9%

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 1.6 тэрбум төгрөг буюу 14.4 хувиар өсөж 12.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	12,414.1	2,770.0	11,044.3	1,369.8	11,990.6	423.5	67.0	12,347.1	1,538.6
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	14,008.9	3,626.6	12,627.7	1,381.2	14,008.9	-	967.3	13,041.6	1,868.1
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	5,402.8	2,101.9	5,044.6	358.2	5,402.8	-	900.3	4,502.6	1,132.7
Өмчлөх бусад хөрөнгө	3,808.0	1,245.3	3,461.2	346.8	3,384.5	423.5	-	3,808.0	803.2

Зээл

Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	1,649.0	847.8	1,142.9	506.0	1,615.3	33.6	211.5	1,437.5	251.9
Нийт зээл	1,765.9	896.1	1,240.4	525.6	1,727.2	38.7	219.8	1,546.2	265.9
Хэвийн	1,568.7	814.1	1,077.2	491.5	1,536.4	32.3	204.3	1,364.4	241.9
Анхаарал хандуулах	50.3	22.4	40.5	9.8	49.7	0.6	6.4	43.9	6.5
Чанаргүй:	146.9	59.6	122.6	24.3	141.1	5.8	9.1	137.8	17.6
-Хэвийн бус	25.6	9.3	20.5	5.1	25.1	0.5	1.7	23.8	3.2
-Эргэлзээтэй	30.8	12.0	26.1	4.7	30.3	0.5	2.7	28.1	4.3
-Муу	90.5	38.3	76.0	14.5	85.7	4.8	4.6	85.9	10.0
(Зээлийн эрсдэлийн сан)	117.0	48.3	97.4	19.5	111.8	5.1	8.3	108.7	14.0
Нийт зээл (төгрөгийн)	1,711.2	854.2	1,199.3	511.8	1,673.2	37.9	192.1	1,519.0	234.6
Нийт зээл (валютын)	54.8	41.9	41.0	13.7	53.9	0.8	27.6	27.1	31.4
Зээлдэгчдийн тоо	1,562,757	505,018	244,249	1,318,508	1,546,804	15,953	260,159	1,302,598	76,982
- Иргэн	746,419	499,689	252,354	494,065	734,082	12,337	299,836	446,583	121,773
- Хуулийн этгээд	1,851	713	1,767	84	1,817	34	108	1,743	223


/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 30.1% буюу 408.1 тэрбум төгрөгөөр өсөж 2021 оны III улирлын байдлаар 1.8 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 116.9 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1.6 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Тайлант улиралд ББСБ-ууд 1.9 их наяд төгрөгийн зээлийг 2.6 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 1.5 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2021 оны III улирлын байдлаар 1,562,757 зээлдэгчийн 1.8 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Нийт зээлийн үлдэгдлийн 88.8 хувийг буюу 1,568.7 тэрбум төгрөгийг хэвийн зээл, 2.9 хувийг буюу 50.3 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 8.3 хувийг буюу 146.9 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 3 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 1.0, 1.1 пунктээр буурсан бол хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 197.2 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 59.3%-д буюу 197.2 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Зураг 4 Зээлийн багцын чанар /хувиар/



Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 66.8% буюу 1.3 их наяд төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 10.5% буюу 203.6 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 66.3% буюу 989.2 тэрбум төгрөг нь бусад ангиллын зээлээс, 11.1% буюу 166.3 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Олгосон зээлийн 89.8% буюу 1.7 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 10.2% буюу 197.3 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 89.8% буюу 1.3 их наяд төгрөг нь иргэдээс, 10.6% нь буюу 157.5 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	16,346.0	0.8%	10,950.3	0.7%	24,310.9	1.4%
2.	Уул уурхай, олборлолт	37,241.6	1.9%	27,238.8	1.8%	49,329.7	2.8%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	26,095.7	1.4%	20,783.3	1.4%	29,673.8	1.7%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	3,658.6	0.2%	1,515.4	0.1%	4,402.2	0.2%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1,067.2	0.1%	1,314.2	0.1%	2,399.9	0.1%
6.	Барилга	119,897.6	6.2%	96,623.8	6.5%	188,971.7	10.7%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	203,619.2	10.5%	166,322.0	11.1%	241,632.4	13.7%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	82,120.0	4.2%	48,186.4	3.2%	71,528.6	4.1%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	18,093.9	0.9%	14,872.7	1.0%	18,310.1	1.0%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	42,605.4	2.2%	39,121.3	2.6%	73,894.5	4.2%
11.	Мэдээлэл холбоо	9,369.5	0.5%	7,420.2	0.5%	8,452.9	0.5%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	31,758.0	1.6%	23,581.1	1.6%	28,555.6	1.6%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	11,207.8	0.6%	8,351.9	0.6%	15,547.8	0.9%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	5,546.3	0.3%	4,829.7	0.3%	3,428.3	0.2%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	13,113.0	0.7%	10,467.0	0.7%	14,890.9	0.8%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1,399.5	0.1%	1,407.4	0.1%	1,311.7	0.1%
17.	Боловсрол	9,221.4	0.5%	9,145.5	0.6%	10,364.6	0.6%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	9,075.3	0.5%	10,603.7	0.7%	12,327.7	0.7%
19.	Бусад	1,291,489.5	66.8%	989,208.3	66.3%	966,592.2	54.7%
<i>Иргэнд олгосон зээл</i>		1,735,569.7	89.8%	1,334,395.2	89.4%	1,528,989.9	86.6%
<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>		197,355.9	10.2%	157,547.9	10.6%	236,935.6	13.4%
НИЙТ		1,932,925.7	100.0%	1,491,943.1	100.0%	1,765,925.5	100.0%


Нийт зээлийн ангиллаас харахад иргэнд олгосон зээлийн 62.3 хувийг хэрэглээнд, үүний 20.2 хувийг автомашинд зориулсан зээл бүрдүүлж байна. Хуулийн этгээдэд олгосон зээлийн 9.2 хувийг бизнесийн зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 18 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	1,735.6	89.8%	1,334.4	89.4%	1,529.0	86.6%
Хэрэглээнд зориулсан зээл	1,203.6	62.3%	880.8	59.0%	899.1	50.9%
Үүнээс: Автомашинд зориулсан зээл	391.1	20.2%	264.1	17.7%	387.6	21.9%
Бизнесд зориулсан зээл	286.1	14.8%	244.2	16.4%	363.6	20.6%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	73.3	3.8%	62.0	4.2%	127.1	7.2%
Бусад зээл	172.6	8.9%	147.5	9.9%	139.2	7.9%
Хуулийн этгээдэд олгосон зээл	197.4	10.2%	157.5	10.6%	236.9	13.4%
Бизнесийн зээл	178.0	9.2%	141.0	9.4%	194.3	11.0%
Автомашинны зээл	3.9	0.2%	5.2	0.3%	12.4	0.7%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	4.6	0.2%	4.5	0.3%	5.1	0.3%
Бусад зээл	10.9	0.6%	6.9	0.5%	25.1	1.4%
НИЙТ	1,932.9	100.0%	1,491.9	100.0%	1,765.9	100.0%

Тайлант улиралд олгосон 1.8 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1-2.5 жилийн хугацаатай олгосон зээл нийт зээлийн 29.4 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 20.6 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 5 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2021 оны III улирлын байдлаар 24 ББСБ үзүүлж байгаа бөгөөд үүний 6 ББСБ нь зөвхөн онлайн зээлийн үйлчилгээ санал болгож байгаа бол 18 ББСБ нь уламжлалт болон дэвшилтэт технологи хослуулан зээл олгож байна. Мөн 7 ББСБ онлайн зээл олгохоор туршилтын аппликэйшн гаргасан байна.

Хүснэгт 19 Уламжлалт болон финтек зээлийн тоо мэдээ

	Зээлийн дүн	Эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Эзлэх хувь	Харилцагчдын тоо	Эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	1,585,624,950.60	89.8%	294,202.00	18.8%	308,440.00	6.8%	5,389.6
Финтек	180,300,512.7	10.2%	1,268,555.00	81.2%	4,221,686.00	93.2%	142.1
Нийт	1,765,925,463.30		1,562,757.00		4,530,126.00		1,130.0

2021 оны III улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшнээр 1.3 сая зээлдэгчийн 180.3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нэг зээлдэгчид дунджаар 142.1 мянган төгрөгийн зээл олгосон байна. Энэ нийт зээлийн дунджаас 8 дахин, уламжлалт хэлбэрээр олгож байгаа зээлийн дунджаас 37.9 дахин бага байна.

Хүснэгт 20 Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд

№	Финтек	Апп нэр
1	Ашид капитал	Simple
2	Лэндмн	lendmn
3	Соно финтек	Sono mongolia
